

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/24/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Б.Должинжав

Утас: 89898557

цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудит санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил

---

## 1.Аудит санал дүгнэлт



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГА Б.БЯМБАЖАВ ТАНАА

2022.02.21 № 2/43  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

0010 0435

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	746,029,958.44	586,570,133.12
33	АВЛАГА	558,731,515.00	543,504,654.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	170,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,650,000.00	-
335	Бусад авлага	553,081,515.00	543,334,654.00
3351	Байгууллагаас авах авлага	553,081,515.00	543,334,654.00
34	УРЬДЧИЛГАА		7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	187,298,443.44	35,865,479.12
351	Түүхий эд материал	304,000.00	304,000.00
35110	Тусгай зориулалттай материал	304,000.00	304,000.00
354	Хангамжийн материал	16,144,443.44	35,561,479.12
35410	Бичиг хэргийн материал	899,700.00	1,169,328.70
35420	Аж ахуйн материал	11,732,441.04	13,853,048.02
35430	Сэлбэг хэрэгсэл	286,000.00	286,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,102,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,226,302.40	6,352,102.40
35600	Мал амьтад	170,850,000.00	12,799,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	477,563,579.18	459,597,627.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	477,563,579.18	459,597,627.84
392	Биет хөрөнгө	366,638,879.30	350,865,377.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	86,060,080.00	86,060,080.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,510,085.90)	(2,868,669.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	254,453,527.00	254,453,527.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(153,170,755.83)	(161,322,927.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,740,835.43	117,955,635.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(100,223,815.34)	(104,704,279.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,601,305.76	20,791,305.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,080,055.37)	(14,443,680.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	270,932,623.46	271,457,036.71
39215	Хуримтлагдсан элэгдэл	(106,689,193.16)	(116,512,650.32)
39217	Ном	524,413.25	-
393	Биет бус хөрөнгө	110,924,699.88	108,732,249.96
39301	Програм хангамж	-	16,469,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл-про хангамж		(3,467,450.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	112,199,700.00	95,729,900.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,275,000.12)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,223,593,537.62	1,046,167,760.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	635,100.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	635,100.00	-
413	Өглөг	635,100.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	117,000.00	-
4136	Бусад өглөг	518,100.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	518,100.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,222,958,437.62	1,046,167,760.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,222,958,437.62	1,046,167,760.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,175,118,077.35	1,175,118,077.35
51101	Өмч: - төрийн	1,175,118,077.35	1,175,118,077.35

512	Хуримтлагдсан үр дүн	(41,478,274.62)	(218,268,951.28)
51210	Өмнөх үеийн үр дүн	(23,559,506.69)	(40,203,274.50)
51220	Тайлант үеийн үр дүн	(17,918,767.93)	(178,065,676.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,318,634.89	89,318,634.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,223,593,537.62	1,046,167,760.96

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	664,070,262.27	424,775,923.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,565,189.90	13,812,128.70
120	Нийтлэг татварын бус орлого	109,565,189.90	13,812,128.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	109,565,189.90	13,812,128.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	109,565,189.90	13,812,128.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554,505,072.37	410,963,795.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382,351,300.00	365,388,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,252,300.00	365,388,300.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,153,772.37	45,575,495.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,070,000.00	37,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,594,759.53	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,489,012.84	8,275,495.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	681,989,030.20	602,841,600.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,989,030.20	602,841,600.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650,381,767.18	517,234,089.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,198,113.35	191,898,756.00
210101	Үндсэн цалин	195,360,239.07	173,811,370.00
210102	Нэмэгдэл	350,000.00	16,360,714.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	487,874.28	1,726,672.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,741,903.00	24,073,749.00
210201	Тэтгэврийн даатгал	16,400,014.00	16,998,305.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,014,778.00	1,887,427.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,649,256.00	1,509,942.25
210204	Ажилгүйдлийн даатгал	333,588.00	334,370.16
210205	Эрүүл мэндийн даатгал	3,344,267.00	3,343,703.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,035,303.00	10,170,893.00
210301	Гэрэл, цахилгаан	671,243.00	754,733.00
210302	Түлш, халаалт	9,279,060.00	9,416,160.00
210303	Цэвэр, бохир ус	85,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	154,453,681.38	182,601,340.02
210401	Бичиг хэрэг	1,113,200.00	1,277,400.00
210402	Тээвэр, шатахуун	102,396,000.00	9,331,937.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,444.00	502,760.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,475,037.38	11,810,243.02
210408	Бараа материал акталсны зардал	-	679,000.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	159,000,000.00
2105	Нормативт зардал	15,207.36	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,207.36	-
2107	Томилолт, зочны зардал	3,013,800.00	1,188,000.00
210702	Дотоод албан томилолт	3,013,800.00	1,188,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	192,030,665.07	74,733,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,806,981.07	69,595,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	532,664.00	841,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,420.00	280,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,600.00	3,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,893,094.02	32,567,451.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,124,300.00	5,921,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,768,794.02	26,645,751.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,607,263.02	85,607,511.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	762,500.00	25,939,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,329,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	762,500.00	610,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,844,763.02	59,668,511.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,844,763.02	59,668,511.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,918,767.93)	(178,065,676.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,918,767.93)	(178,065,676.78)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-23,559,506.69	1,150,231,223.55
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-23,559,506.69	1,150,231,223.55
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-17,918,767.93	-17,918,767.93
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,175,118,077.3	89,318,634.89	-41,478,274.62	1,222,958,437.62
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.3	89,318,634.89	-41,478,274.62	1,222,958,437.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,275,000.12	1,275,000.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.3	89,318,634.89	-40,203,274.50	1,224,233,437.74
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-181,798,226.74	-178,065,676.78
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,175,118,077.3	89,318,634.89	-222,001,501.24	1,046,167,760.96

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	554,604,072.37	423,413,795.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	198,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	198,000.00	-
120009	Бусад орлого	198,000.00	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	554,406,072.37	423,413,795.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	382,252,300.00	365,388,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,252,300.00	365,388,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,153,772.37	58,025,495.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,070,000.00	37,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,594,759.53	5,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,489,012.84	15,075,495.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	553,578,172.37	423,413,795.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,578,172.37	423,413,795.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	521,970,909.35	337,806,284.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,444,725.35	193,192,299.00
210101	Үндсэн цалин	130,204,340.58	149,814,843.00
210102	Нэмэгдэл	43,049,606.49	35,372,652.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,190,778.28	8,004,804.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,499,600.00	22,953,457.00
210201	Тэтгэврийн даатгал	17,240,400.00	16,210,013.80
210202	Тэтгэмжийн даатгал	1,814,800.00	1,804,449.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,451,800.00	1,443,559.14
210204	Ажилгүйдлийн даатгал	363,000.00	317,766.95
210205	Эрүүл мэндийн даатгал	3,629,600.00	3,177,668.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,235,303.00	10,468,893.00
210301	Гэрэл, цахилгаан	671,243.00	754,733.00
210302	Түлш, халаалт	9,279,060.00	9,416,160.00
210303	Цэвэр, бохир ус	285,000.00	298,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,840,344.00	5,390,260.00
210401	Бичиг хэрэг	579,100.00	492,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,369,600.00	3,956,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,444.00	576,860.00
210404	Ном, хэвлэл		364,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	422,200.00	
2105	Нормативт зардал	81,600.00	181,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	81,600.00	181,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	326,800.00	261,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	218,800.00	175,000.00
210602	Тавилга	108,000.00	
210604	Урсгал засвар	-	86,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,013,800.00	1,188,000.00
210702	Дотоод албан томилолт	3,013,800.00	1,188,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	291,375,437.00	99,924,525.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	290,068,253.00	87,586,525.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	532,664.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	234,420.00	841,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,000.00	280,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	474,100.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		10,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,300.00	4,246,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,300.00	4,246,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,607,263.02	85,607,511.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	762,500.00	25,939,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		25,329,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	762,500.00	610,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,321,590.65	52,867,641.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,321,590.65	52,867,641.00
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,025,900.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,025,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,025,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,025,900.00	-
223001	Бусад хөрөнгө	1,025,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,025,900.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
		365,388,300.00	312,520,659.00	(52,867,641.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,388,300.00	312,520,659.00	(52,867,641.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	339,449,300.00	286,581,659.00	(52,867,641.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,435,100.00	193,192,299.00	(7,242,801.00)
210101	Үндсэн цалин	152,612,700.00	149,814,843.00	(2,797,857.00)
210102	Нэмэгдэл	39,594,800.00	35,372,652.00	(4,222,148.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,227,600.00	8,004,804.00	(222,796.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,177,600.00	22,953,457.00	(3,224,143.00)
210201	Тэтгэврийн даатгал	17,769,400.00	16,210,013.80	(1,559,386.20)

210202	Тэтгэмжийн даатгал	2,102,100.00	1,804,449.09	(297,650.91)
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,681,600.00	1,443,559.14	(238,040.86)
210204	Ажилгүйдлийн даатгал	420,500.00	317,766.95	(102,733.05)
210205	Эрүүл мэндийн даатгал	4,204,000.00	3,177,668.02	(1,026,331.98)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,044,000.00	10,468,893.00	(7,575,107.00)
210301	Гэрэл, цахилгаан	1,758,900.00	754,733.00	(1,004,167.00)
210302	Түлш, халаалт	15,475,700.00	9,416,160.00	(6,059,540.00)
210303	Цэвэр, бохир ус	809,400.00	298,000.00	(511,400.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	5,616,900.00	5,390,260.00	(226,640.00)
210401	Бичиг хэрэг	492,300.00	492,300.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,956,800.00	3,956,800.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	787,800.00	576,860.00	(210,940.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,000.00	364,300.00	(15,700.00)
2105	Нормативт зардал	181,200.00	181,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	181,200.00	181,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	261,400.00	261,400.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	175,000.00	175,000.00	-
210604	Урсгал засвар	86,400.00	86,400.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,212,300.00	1,188,000.00	(24,300.00)
210702	Дотоод албан томилолт	1,212,300.00	1,188,000.00	(24,300.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,270,800.00	48,699,900.00	(34,570,900.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,363,300.00	36,361,900.00	(34,001,400.00)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	841,500.00	841,500.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	850,000.00	280,500.00	(569,500.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,250,000.00	4,246,250.00	(3,750.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,250,000.00	4,246,250.00	(3,750.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,939,000.00	25,939,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,939,000.00	25,939,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,329,000.00	25,329,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	610,000.00	610,000.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>365,388,300.00</b>	<b>312,520,659.00</b>	<b>(52,867,641.00)</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>365,388,300.00</b>	<b>312,520,659.00</b>	<b>(52,867,641.00)</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	365,388,300.00	312,520,659.00	(52,867,641.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-
610001	Төсвийн байгууллага			-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	-
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-
620004	Гэрээт ажилтан			-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172252772.37	58025495.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172252772.37	58025495.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158729600.00	51224625.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14253000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	14253000.0	
2107	Томилолт, зочны зардал	1615000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1615000.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	142861600.00	51224625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142861600.0	51,224,625.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13523172.37	6800870.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13523172.37	6800870.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13523172.37	6800870.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	13523172.4	
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		6800870.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172252772.37	58025495.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172252772.37	58025495.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	163650000.0	37,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2594759.5	5,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6008012.8	15,075,495.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд баланс дахь авлагатай холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 01 дугаар сарын 21-нээс 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь "Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрийн салбарт орчин үеийн шийдэл бүхий инновацийг нэвтрүүлж, иргэдийн сэтгэл ханамжийг хангаж стандартын шаардлага хангасан баруун бүсийн хөдөө аж ахуйн салбарт тэргүүлэх байгууллага болно" гэсэн эрхэм зорилгын хүрээнд байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт дэвшүүлэн 98.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт оржээ. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*
- *Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар "Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*

Тухайн онд байгууллагын дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллажээ.

ХХААХҮЯ-ны салбар байгууллагуудын хэмжээнд нэгдсэн журмаар мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тухайн байгууллага санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, түүнчлэн эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 365,388.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,307.8 мянган төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 5,846.2 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 181,158.3 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь бараа материалын мал амьтдын данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Өмнөх оны үзүүлэлтэй харьцуулахад дансны авлагын үлдэгдэл 15,226.9 мянга, бараа материалын үлдэгдэл 151,433.0 мянга, үндсэн хөрөнгийн цэвэр дүн 14,498.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэл дэх 543,504.6 мянган төгрөгийн 170.0 мянган төгрөг нь ажилчидтай холбогдсон авлага, 5000.0 мянган төгрөг нь Аж мандал Ховд ХХК-аас өвс тэжээл авах авлага, 309.9 мянган төгрөг нь Жаргалант тамир ХХК-руу хоорондын тооцооны авлага, 484000.0 мянган төгрөг нь Баялаг буянт ХХК-тай холбогдсон зээлийн авлага, 34900.0 мянган төгрөг нь Алтайн номадс ХХК-тай холбогдсон авлага, 19121.5 мянган төгрөг нь 2012 онд МЭУСАХЗ-ын зарцуулагдаагүй үлдэгдлийг Сангийн яам руу төвлөрүүлэхдээ бүртгэл хөтлөөгүй он дамжсаар барагдаагүй авлага байна.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 187,298.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 35,865.4 мянган төгрөг болж 151,433.0 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 28,960.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 7412.4 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 32,035,8 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 159,000.0 мянган төгрөгийн мал амьтдыг балансаас шилжүүлэн бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 855,512.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 862,917.2 мянган төгрөг болж 7,404.8 мянган төгрөгөөр өссөн нь Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанаас үнэ төлбөргүй хөрөнгө бэлтгэсэн байна.

Тайлант оны эхэнд 635.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бол тухайн онд бүрэн барагдуулж, оны эцэст өргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1,222,958.4 мянган төгрөг байсан ба оны эцэст 1,042,435.2 мянган төгрөг болж тайлант онд 180,523.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 1275.0 мянган төгрөгийн залруулах бичилт хийгдсэн ба нийт хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 222,001.5 мянган төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хүнс, хөдөө аж ахуйн газар төсвийн төсөлд 2021 оны нийт зардлыг 365,388.3 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 365,388.3 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба дээд шатны төсвийн захирагч тус байгууллагад 365,388.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 365,388.3 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 312,520.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулагдаагүй 52,867.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,520.7 мянган төгрөг буюу 85.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 7242.8 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3224.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7575.1 мянга, хангамж, бараа материалын зардлыг 226.6 мянга, томилолт, зочны зардлыг 24.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 34570.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс хадлан газар тариалангийн трактор иж бүрдэл худалдан авах хөрөнгийн санхүүжилт 37300.0 мянга, Баялаг буянт ХХК-аас хугацаа хэтэрсэн зээлийн төлөлт 6000.0 мянга, Алтайн номадс ХХК-аас авлагын барагдуулалт 800.0 мянга, онцгой байдлын газраас ковид-19 зардлын санхүүжилт 3368.8 мянга, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт данснаас 5650.0 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого 4906.6 мянга, нийт 58025.4 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Дээрх эх үүсвэрээс 51224.6 мянган төгрөгийг холбогдох арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулж, зээл, авлагын барагдуулалт 6800.0 мянга, зарцуулагдаагүй 0.8 мянга нийт 6800.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна. Үүнд:

1. Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас трактор, хөдөө аж ахуйн машин дамжуулан зээлээр худалдан авах гэрээний дагуу аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 37300.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хадлангийн зориулалтын трактор, техник иж бүрдлийг олгох менежментийн гэрээгээр хадлангийн иж бүрдлийн 10 хувийг аймгаас төлөх бөгөөд 2019 оноос эхлэн жилийн 2 хувийн хүүгийн хамт уг төхөөрөмжийн үнийг эзэмшигч аж ахуйн нэгж аймгийн өвсний нөөц бэлтгэж өгөх замаар төлөхөөр тусгасан учир хүлээлгэн өгсөн өвс тэжээл аймгийн ЗДТГ хяналтад байна.

2. ХХААХҮЯ-аас 2019 онд олгосон 20 тонн төмсний үрийг данс бүртгэлд тусгаагүй, зарцуулалтад хэрэгжүүлэх хяналт сул байна.

3. Тус байгууллагын данс бүртгэлд 543,504.6 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 538021.5 мянган төгрөгийн авлага нь он дамжсан, насжилт өндөртэй авлага байна. Үүнээс: Алтайн номадс ХХК-ны 34900.0 мянган төгрөгийн авлагаас тайланд онд 800.0 мянган төгрөг барагдуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай байгуулсан гэрээний хуваариас 2200.0 мянган төгрөг дутуу, Баялаг буянт ХХК-ны 490000.0 мянган төгрөгийн

авлагаас тайлант онд 6000.0 мянган төгрөг барагдуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай байгуулсан гэрээний хуваариас 7500.0 мянган төгрөг дутуу барагдуулсан зөрчилд зөвлөмж өглөө. 19121.5 мянган төгрөг нь 2012 онд МЭУСАХЗ-ын зарцуулагдаагүй үлдэгдлийг Сангийн яам руу төвлөрүүлэхдээ зөрүүтэй бүртгэж он дамжсаар барагдаагүй авлага байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах ажил гүйлгээ хийгдсэн байна.

Сэлэнгэ, грепорт үүлдрийн хээлтүүлэгч бухан бярууг 2019 онд сумдад хуваарилж өгсөн боловч сумдын ЗДТГ орлого аваагүй, данс бүртгэлд тусгаагүй байсан учир 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2020 онд ХХААГ буцаан орлого авч, 2021 онд аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн дагуу 159000.0 мянган төгрөгийн мал амьтдыг сумдын ЗДТГ-ын балансад шилжүүлсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1-12 саруудад болон улирлаар мэдээлээгүй, 1 болон 2 дугаар саруудад батлагдсан төсөв оруулсан ба бусад саруудад төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг оруулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, санхүүгийн тайлан (бүтэн, хагас жилээр), санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллийг мэдээлээгүй байсныг аудитын явцад бүрэн мэдээлж зөрчлийг залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4601.8 мянган төгрөгийн төлбөрийн 4 актыг бүрэн барагдуулж, албан шаардлагаар өгсөн 180114.6 мянган төгрөгийн зөрчлийг арилган ажилласан ба, өгсөн 3 зөвлөмжөөс 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил дутагдал давтагдсан байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар он дамжсан насжилт өндөртэй авлагын барагдуулалт, төмсний үрийн зарцуулалттай холбоотой асуудлыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 66,057.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 37236.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг аудитын явцад залруулж, 28821.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аудитын явцад байгууллагын нягтлан бодогч шилэн дансны цахим системд оруулаагүй, дутуу мэдээллийг нөхөж мэдээлэв.
2. Байгууллагын данс бүртгэлд дэх 3236.2 төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг хүлэмжийг аймгийн цагдаагийн газарт, 2500.0 төгрөгийн үнэ бүхий 1 хүлэмжийг хот тохижилтын газарт, 12500.0 мянган төгрөгийн үнэ бүхий услалтын системийг Мянган угалзат ОНӨҮГ-ын үйл ажиллагаанд ашиглуулахдаа хөрөнгө эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрээний үүргийн хэрэгжилт тооцож ажиллав.
3. ХХААХҮЯ-аас 2019 онд олгосон 20 тонн буюу 19000.0 мянган төгрөгийн үнэ бүхий төмсний үрийн тооцоог данс бүртгэлд тусгуулав.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн залруулга, санхүүгийн баримтын бүрдэл дутуу нийт 37,236.2 мянган төгрөгийн зөрчлийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, зөрчлийг арилган 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 тоот албан тоотоор ирүүлэв

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. **Авлагын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Алтайн номадс ХХК-ны 34900.0 мянган төгрөгийн авлагаас 2200.0 мянга, Баялаг буянт ХХК-ны 490000.0 мянган төгрөгийн авлагаас 7500.0 мянган төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай байгуулсан гэрээний хуваариас дутуу барагдуулсан байна. 2012 оноос хойш он дамжин нэр зөрүүтэй бүртгэгдсэн 19121.5 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцүүлж, 2012 оноос хойш он дамжин нэр зөрүүтэй бүртгэгдсэн 19121.5 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн авлагыг ХХААХҮЯ-тай тооцоо нийлж баталгаажуулах, гэрээний дагуу авлагын барагдуулалтад хяналт тавих.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХААГ	4	66,057.7	3	37236.2					1	28821.5

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:****ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР****АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН****ТАЙЛАНГ БИЧСЭН:****АУДИТОР: Б.ДОЛЖИНЖАВ**



